

## 1. Нэг эрүүл мэнд

*Амьтан-хүн-хүрээлэн буй орчны газар нутгийн давхцалд эрүүл мэндэд учирдаг аюулыг даван туулахад малын эрүүл мэндийн салбарын үүрэг нэн чухал юм.*

### Хураангуй

КОВИД-19 цартахал нь хүний эрүүл мэнд, малын эрүүл мэнд, байгаль орчин хоорондын харилцан хамаарлын чухлыг онцолж, "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалын талаар хэлэлцүүлэг, үйл ажиллагаа өрнүүлэх болов. Зооноз цартахлаас гадна бичил биетний тэсвэржилт, хүнсний аюулгүй байдлын сорилтууд, зооноз болон дамжуулагчдаар дамждаг орхигдсон өвчин зэрэг эрүүл мэндэд заналхийлж буй асуудлууд нь цогц, хамтын шийдэл гаргахыг шаардаж байна.

Дэлхий дахинд тулгарч буй эдгээр сорилтуудыг шийдвэрлэхэд малын эрүүл мэндийн салбар чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Энэ утгаараа Мал эмнэлгийн алба болон малын эрүүл мэндийн бусад эрх бүхий удирдах байгууллагуудын манлайлал дэлхий нийтийн эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) нь эрүүл мэндэд учирч буй эдгээр аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авахад чиглэсэн төлөвлөлтийг амжилттай гүйцэтгэхийн тулд олон салбарын түншлэлийг дэмждэг. Тус байгууллага нь Мал эмнэлгийн албанд дутагдаж буй ажиллах хүчний нөөцийг нэмэгдүүлэх, мал эмнэлгийн салбарт Нэг эрүүл мэндийн бодлого, стратегийн үр дүнтэй хэрэгжилтийг хангахад зориулж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг уриалж байна.

### Бодлогын зөвлөмж

2023 оны эхээр гаргасан дэлхийн Дөрвөн талт үйл ажиллагааны уриалгад үндэслэн Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас малын эрүүл мэндийн болон бусад салбарт Нэг эрүүл мэндийн үзэл баримтлалыг бэхжүүлэх зорилгоор бодлогод суурилсан дараах шийдлүүдийг зөвлөмж болгож байна. Үүнд:

- Олон улсын улс төрийн мөрийн хөтөлбөрт “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалыг үндсэн зарчим болгон салбар дундын эрүүл мэндийн засаглалын тэргүүлэх чиглэлийг тогтооход дэмжлэг үзүүлэх;
- Дөрвөн талт Нэг эрүүл мэндийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зардлыг төсөвлөж, эрэмбэлсэн Нэг эрүүл мэндийн бодлого, стратеги, төлөвлөгөөг дэмжих замаар Нэг эрүүл мэндийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Үндэсний хэмжээнд Нэг эрүүл мэндийн засаглал, салбар дундын хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэх, мөн оролцогч талуудыг зураглах, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зэргээр Нэг эрүүл



**товч танилцуулга**

мэндийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, Нэг эрүүл мэндийн мониторинг, үнэлгээний тогтолцооны хэмжүүрүүдийг боловсруулах чиглэлээр улс орнуудад дэмжлэг үзүүлэх;

- Тусгай, хүлээн зөвшөөрөгдсөн, уялдуулсан боловсролын хөтөлбөр, үргэлжилсэн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан мал эмнэлгийн салбарын мэргэжилтнүүдийн Нэг эрүүл мэндийн чадавхыг нэгдсэн байдлаар сайжруулах;
- Амьтан-хүн-хүрээлэн буй орчны газар нутгийн давхцалд зооноз халдвар тархах эрсдэлийг өдөөгч хүчин зүйлд анхаарал хандуулах замаар цартахал, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тогтвортой байдлыг хангах;
- "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалтай холбоотой шинжлэх ухааны мэдлэг, нотолгоо, технологийг бий болгох, харилцан солилцохыг хөхиүлэн дэмжих;
- Нэг эрүүл мэндийн стратеги, төлөвлөгөөг өргөн хүрээнд хэрэгжүүлэхийн тулд санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Нийгмийн бүх түвшний оролцогч тал, бүлэгт хүрсэн зохистой мэдээлэл харилцаа, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх замаар Нэг эрүүл мэндийн үйл ажиллагаанд нийгмийг бүхэлд нь татан оролцуулахад дэмжлэг үзүүлэх.

## 2. Шинэ болон сэргэж буй зоонозын эпидеми, цартахалтай тэмцэхэд "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалын ач холбогдол

*Малын эрүүл мэндийн салбарын хэтийн төлөв*

### Хураангуй

Шинэ болон сэргэж буй зооноз өвчин гэдэг нь мал амьтан, хүний хооронд дамжих чадвартай эмгэгтөрүүлэгчдээр үүсгэгддэг, популяцийн дунд тохиолдол, тархалт нь ихэссэн, эсхүл бүүрсны дараа дахин сэргэсэн халдварыг хэлнэ. Хүнд илэрч буй шинэ халдварт өвчнүүдийн 75 гаруй хувь нь амьтнаас дамжсан гэсэн тооцоо байдаг нь мал амьтан үүсгэгчийг агуулах замаар эдгээр өвчний хөдлөл зүйд гол үүрэг гүйцэтгэдгийг харуулж байна. Зэрлэг амьтад бол шинээр гарч буй зооноз өвчнүүдийн үүсгэгчийг хамгийн гол агуулагч юм (жишээ нь, шар чичрэг, амьсгалын цочмог халтай хам шинж). Мал сүрэг нь шинэ зооноз өвчин дамжуулах чадвартайгаас гадна (жишээ нь, үхрийн тархи сархиагтах эмгэг, шувууны томуу) зэрлэг амьтаас халдсан эмгэгтөрүүлэгч малын биед үржиж олширдог.

Шинэ болон сэргэж буй зооноз өвчний илрэл нь олон хүчин зүйлтэй холбоотой бөгөөд тэдгээрийн зарим нь газар ашиглалт болон уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүний үйл ажиллагаатай хамааралтай. Шинэ болон сэргэж буй зооноз өвчинтэй холбоотой хүчин зүйл, үйл явцыг ойлгох нь ирээдүйд гарч болзошгүй өвчний дэгдэлтээс сэргийлэх, үүнтэй холбоотой эрсдэлийг урьдчилан таамаглахад чухал ач холбогдолтой.

Шинээр гарч буй зооноз өвчний хөдлөл зүйд нөлөөлдөг олон хүчин зүйл нь өвчний дэгдэлтийн эсрэг арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэхэд "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлал зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Шинэ болон сэргэж буй зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) нь малын эрүүл мэндийн салбарт Нэг эрүүл мэндийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх, Мал эмнэлгийн албаны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, салбар дундын түншлэлийг бэхжүүлэхийг дэмждэг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), ДМАЭМБ-аас бүрдсэн Дөрвөн тал хамтран эрүүл мэндэд учирч буй аюул заналтай илүү үр дүнтэй тэмцэх зорилгоор Нэг эрүүл мэндийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө (2022–2026 он) (*цаашид ОН IPA гэх*) боловсруулсан бөгөөд үүний Үйл ажиллагааны чиглэл 2 нь шинэ болон сэргэж буй зоонозын эпидеми, цартахлын эрсдэлийг бууруулах тухай юм. ДМАЭМБ нь мал эмнэлгийн салбарт дээрх Үйл ажиллагааны чиглэл 2-ын бодлогыг уялдуулахад дэмжлэг үзүүлж байна.

Бодлогын зөвлөмж

ДМАЭМБ нь шинэ болон сэргэж буй зооноз өвчнүүдээс “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын дор урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор бодлогод суурилсан дараах шийдлүүдийг зөвлөмж болгож байна. Үүнд:

**Бодлого, институтийн түвшинд:**

- Төр, хувийн хэвшлийн түншлэл, жендэрийн тэгш байдлыг хангах зэрэг олон салбар, нийгмийг бүхэлд нь хамарсан арга барилыг баримтлах замаар үндэсний Нэг эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө, бодлого боловсруулах буюу ОН JPA-тэй уялдуулах;
- Хууль эрх зүйн орчин, хууль тогтоомжийг сайжруулах, хүний болон санхүүгийн зохистой нөөцийг бүрдүүлэх зэрэг урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх хүчин зүйлд анхаарал хандуулах замаар шинэ болон сэргэж буй зооноз өвчний талаар дэлхий нийтийн засаглалыг бэхжүүлэх;
- Зооноз өвчний асуудалд нийгмийн бүлгүүдийн оролцоог хангах бодлого, стратеги, эрсдэлийн хамтарсан мэдээлэл харилцааг хөгжүүлэх, сайжруулах;
- Хүн-мал-зэрлэг амьтдын газар нутгийн давхцалд эмгэгтөрүүлэгч амьтны төрөл дамжин халдварлахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор үндэсний хэмжээнд Нэг эрүүл мэндийн тандалтыг сайжруулах; Шинэ болон сэргэж буй зооноз өвчнийг цаг алдалгүй, үр дүнтэй илрүүлэх зорилгоор мал эмнэлгийн лабораторийн чадавхыг бэхжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Мал аж ахуйг тогтвортой бус аргаар эрчимжүүлэх, ой устгах замаар газар ашиглалтыг өөрчлөх зэрэг зооноз өвчин үүсэх, амьтны төрөл дамжин халдварлах, тархахад хүргэдэг хүчин зүйлсэд мониторинг хийж, бууруулахад дэмжлэг үзүүлэх.

**Хөтөлбөрийн түвшинд:**

- ОН JPA-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний Нэг эрүүл мэндийн салбар дундын зохицуулах механизмын хүрээнд шинээр гарч буй зооноз өвчнүүдийн талаар техникийн ажлын хэсэг байгуулах, чадавхжуулах;
- Дэгдэлтийн хамтарсан судалгааны стандарт ажлын заавар боловсруулж, шинээр гарч болзошгүй зооноз өвчнүүдийн талаар эрсдэлийн хамтарсан үнэлгээг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулах;
- Шинэ болон сэргэж буй зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, тэмцэх арга хэмжээг сайжруулах зорилгоор зооноз өвчин үүсгэгч амьтны төрөл дамжин халдварлахтай холбоотой хүчин зүйлсийн талаарх өгөгдөл мэдээллийг салбар болон улс орнуудын хооронд солилцох;
- Үндэсний болон бүсийн түвшинд баримтлах бичил биетний эсрэг эмийн хариуцлагатай, зохистой хэрэглээний зааврыг ДМАЭМБ-ын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах, шинэчлэх;

**товч танилцуулга**

- Хамрагдалт болон сүргийн дархлааг өндөр түвшинд хүргэх, мутаци үүсэх эрсдэлийг бууруулах, бичил биетний эсрэг эмийн хэрэгцээг хязгаарлах зорилгоор гэрийн тэжээвэр амьтдад зориулсан вакцинжуулалтын протоколыг найдвартай, хүртээмжийг нь хялбар болгоход ахиц гаргах;
- Хүнсний сүлжээн дэх биохамгааллын арга хэмжээг ДМАЭМБ-ын олон улсын стандартад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зэрлэг болон гэрийн тэжээвэр амьтдын хавьтлыг бууруулахад чиглэсэн заавар, сайн дадлыг хуваалцах.

**Техникийн түвшинд:**

- Мал эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулж зооноз өвчин шинээр гарах, сэргэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэх чиглэлээр эрсдэлийн хамтарсан үнэлгээ хийх, эрсдэлийн мэдээлэл харилцааны чадавх бэхжүүлэх Нэг эрүүл мэндийн хамтарсан сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, тэмцэх арга хэмжээнд орон нутгийн нөхцөл байдлыг харгалзахын тулд шийдвэр гаргах үйл явцад аймаг орон нутгийн мэргэжилтнүүд, засаг захиргаа, нутгийн иргэд, бүлгүүдийг татан оролцуулах;
- Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг онилсон байдлаар зохион байгуулах зорилгоор шинэ болон сэргэж буй зооноз өвчинтэй холбоотой эмгэгтөрүүлэгчийн шинж чанар, амьтны төрөл дамжсан халдвар, түүнд нөлөөлөгч хүчин зүйл, дэлхийн хэмжээнд үзүүлж буй дарамтыг судлах ажлыг дэмжих.

### **3. Нутагшмал зооноз, халуун орны болон дамжуулагчдаар дамждаг орхигдсон өвчнүүдтэй мал эмнэлгийн салбар “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын дор тэмцэх нь**

#### Хураангуй

Нутагшмал зооноз нь бага, дунд орлоготой орнууд болон мал ахуйтай ойр хүмүүст харьцангуй нөлөөлдөг халдварт өвчин юм. Үүнд галзуу, бруцеллёз, бэтэг болон бусад өвчин багтана. Нутагшмал зооноз өвчнүүдийн дийлэнх нь бага, дунд орлоготой орнуудын ядуу буурай, анхаарлын гадна оршдог хүн ам, амьтны популяцид голчлон нөлөөлдөг тул дэлхийн улс төр, судалгааны хөтөлбөрт бараг багтдаггүй бөгөөд тэдгээрийг халуун орны орхигдсон өвчнүүд гэж ангилдаг. Нутагшмал өвчнүүд ихэвчлэн богино хугацаанд, өргөн хүрээнд тархдаггүй нь тэднийг тэргүүлэх ач холбогдол багатай гэж үзэхэд хүргэдэг. Нутагшмал болон халуун орны орхигдсон зарим өвчин шүмүүл гэх мэт дамжуулагчдаар дамждаг. Африк, Ази, Төв болон Өмнөд Америкийн зарим орон, ялангуяа бага, дунд орлоготой орнуудын цаг уурын нөхцөл нь эдгээр өвчний гаралт нэмэгдэх, тасралтгүй үргэлжлэхэд төгс тохирдгоос гадна уур амьсгалын өөрчлөлт халдварлалтыг хүрдасгаж байна.

Эдгээр өвчнүүдтэй олон салбар хамтарч тэмцэх нь хамгийн үр дүнтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхийн тулд Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-аас “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалыг дэмжиж байна. Энэхүү үзэл баримтлал нь олон салбарыг хамарсан түншлэлийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, тэмцэх арга хэмжээг сайжруулахад орон нутгийн мал эмнэлгийн байгууллага, нийгмийн бүлэг, засаг захиргаа болон холбогдох бусад талуудтай хүчээ нэгтгэх боломж олгодог.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), ДМАЭМБ-аас бүрдсэн Дөрвөн тал хамтран амьтан-хүн-хүрээлэн буй орчны газар нутгийн давхцалд эрүүл мэндэд учирдаг аюултай илүү үр дүнтэй тэмцэх зорилгоор тогтолцоо, чадавхаа нэгтгэх Нэг эрүүл мэндийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө (2022–2026 он) (ОН JPA) боловсруулсан бөгөөд үүний Үйл ажиллагааны чиглэл 3 нь нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдтэй “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын дор тэмцэх, устгах тухай юм. ДМАЭМБ нь мал эмнэлгийн салбарт дээрх Үйл ажиллагааны чиглэл 3-ын бодлогыг уялдуулахад дэмжлэг үзүүлж байна.

Бодлогын зөвлөмж

ДМАЭМБ нь нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдээс “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын дор урьдчилан сэргийлэх, тандах, тэмцэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор бодлогод суурилсан дараах шийдлүүдийг зөвлөмж болгож байна. Үүнд:

**Бодлого, институцийн түвшинд:**

- Засаг захиргаа, эрх бүхий удирдах байгууллага, бусад байгууллага, уугуул иргэд, орон нутгийн бүлгүүд хооронд салбар дундын хамтын ажиллагаа, зохицуулалтыг бэхжүүлэхийн тулд “Нэг эрүүл мэнд үзэл” баримтлалыг орон нутгийн болон үндэсний түвшинд уялдуулах;
- Нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдийн асуудлаар эрсдэлийн хамтарсан мэдээлэл харилцаа, олон нийтийн оролцоог хангах бодлого, стратегийг боловсруулах, сайжруулах;
- Нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдийг мал амьтанд эрт илрүүлэх, оношлоход нь зориулж орон нутгийн мал эмнэлгийн байгууллагуудад олгох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Мал амьтны өвчлөлийн дарамтын өгөгдлийг оролцуулан нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдийн өгөгдөл мэдээллийг үндэсний болон орон нутгийн түвшинд цуглуулахад дэмжлэг үзүүлэх, тайлан мэдээг чанаржуулах, малын эрүүл мэндийн өгөгдлийг Дэлхийн малын эрүүл мэндийн мэдээллийн систем (WAHIS) болон Дэлхийн эрт сэрэмжлүүлэх систем (GLEWS+)-д мэдээлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хангалттай нөөц хуваарилах.

**Хөтөлбөрийн түвшинд:**

- ОН JPA-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдийг хамруулсан үндэсний Нэг эрүүл мэндийн салбар дундын зохицуулах механизмыг бий болгох;
- Нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, тандах, тэмцэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, дээрх өвчнүүдийн халдварлалт өндөртэй нутаг дэвсгэр дэх мал эмнэлэг, нийтийн эрүүл мэнд, байгаль орчны салбарууд хоорондын холбогдох үйл ажиллагааны зохицуулалт, мэдээлэл харилцаа, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хуулиар олгогдсон бүрэн эрх, хангалттай нөөц бүхий салбар дундын техникийн ажлын хэсгүүдийг улсын хэмжээнд байгуулах;
- Гучин он гэхэд ТЭГ болгох стратеги төлөвлөгөөний дагуу мал амьтныг галзуугийн эсрэг вакцинжуулалтад хамруулах хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдийг устгах, тэмцэх хөтөлбөрүүдийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

*товч танилцуулга*

- Нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүд, мал амьтны өвчлөлийн дарамт, хүн, амьтан, дамжуулагчийн популяци дахь халдвар хоорондын уялдаа холбооны талаарх шинжлэх ухааны судалгаа, түүнчлэн өвчний эрт илрүүлгийг сайжруулах зорилгоор боломжийн үнэ өртөгтэй мал эмнэлгийн оношилгооны аргуудыг судлах, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

**Техникийн түвшинд:**

- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр орон нутгийн мал эмнэлгийн мэргэжилтнүүд, засаг захиргаа, уугуул иргэд, орон нутгийн бүлгүүдэд сургалт зохион байгуулах, боловсрол олгох;
- Орон нутгийн нөхцөл байдалд нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд шийдвэр гаргах үйл явцад аймаг орон нутгийн мэргэжилтнүүд, эрх бүхий удирдах байгууллага, нутгийн иргэд, бүлгүүдийг татан оролцуулах;
- Үндэсний хэмжээнд болон бусад түвшинд үнэн зөв мэдээлэл хүргэхийн тулд нутагшмал зооноз, халуун орны орхигдсон өвчнүүд, дамжуулагчдаар дамждаг өвчнүүдийн дарамт болон тэмцэх, устгах арга хэмжээнд зориулсан хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлүүдийн талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудад сургалт зохион байгуулах.



#### 4. Хүнсний аюулгүй байдлын эрсдэлд малын эрүүл мэндийн салбар анхаарал хандуулах нь

*“Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал бүхий ‘Малчны хотноос хэрэглэгчийн ширээ хүртэл’ зарчим*

##### Хураангуй

Хүнс бол мал амьтан, хүний эрүүл мэндийг тодорхойлогч гол хүчин зүйл бөгөөд аюулгүй, шим тэжээлтэй, эрүүл хүнс хэрэглэх нь хүний үндсэн эрх юм. Амьтны гаралтай хүнсээр дамждаг аюулаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хянах нь хүн амыг хүнсээр дамждаг өвчин, халдвараас хамгаалахад чухал ач холбогдолтой.

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) нь амьтны гаралтай хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор бодлого боловсруулах, шийдвэр гаргахад мэдээлэл өгч, олон улсын стандарт боловсруулдаг. Ферм болон төхөөрөх үйлдвэрүүдэд малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын стандартыг хангуулахын тулд ДМАЭМБ нь улс орнуудын Мал эмнэлгийн алба болон бусад эрх бүхий удирдах байгууллагуудтай хамтарч ажилладаг. Жишээлбэл, ДМАЭМБ нь ферм болон төхөөрөх үйлдвэрүүдэд хяналт тавих чиглэлээр Мал эмнэлгийн албыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлдэг. Хүнсний сүлжээн дэх эрсдэлийн дүн шинжилгээнд “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалыг уялдуулснаар хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, анхаарал хандуулах боломжтой болно.

ДМАЭМБ нь стандарт, заавар, дадлын код бүхий цуврал нийтэлдэг Кодекс Алиментариус Хороонд идэвхтэй хувь нэмэр оруулдаг. Тус Хороог 1963 онд хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалах, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах ажиллагаанд шударга дадлыг дэмжих зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ) болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) хамтран байгуулжээ. ДМАЭМБ нь Дэлхийн худалдааны байгууллагын Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (SPS хэлэлцээр)-т малын эрүүл мэнд, зооноз өвчинтэй холбоотой стандартын лавлах байгууллагын үүрэг гүйцэтгэдэг. SPS хэлэлцээр нь хүн-амьтан-хүрээлэн буй орчны газар нутгийн давхцал дах аюулыг бууруулахад тус дөхөм болж, дэлхий дахинд хэрэгжүүлж буй эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний ил тод байдлыг сайжруулдаг.

ХХААБ, ДЭМБ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), ДМАЭМБ-аас бүрдсэн Нэг эрүүл мэндийн Дөрвөн талт хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндэд учирдаг аюултай илүү үр дүнтэй тэмцэх зорилгоор тогтолцоо, чадавхаа нэгтгэх Нэг эрүүл мэндийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө (2022–2026 он) (ОН JPA) боловсруулсан. Үйл ажиллагааны чиглэл 4 нь хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, удирдах, мэдээлэл харилцааг зохион байгуулахад “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалыг мөрдөх тухай юм. ДМАЭМБ нь мал эмнэлгийн салбарт дээрх Үйл ажиллагааны чиглэл 4-ийн бодлогыг уялдуулахад дэмжлэг үзүүлж байна.

Бодлогын зөвлөмж

ДМАЭМБ нь "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалыг бэхжүүлэх, малын эрүүл мэндийн салбар болон бусад салбар дахь хүнсний аюулгүй байдалд учирч буй аюулыг арилгахын тулд дараах бодлогод суурилсан шийдлүүдийг зөвлөмж болгож байна. Үүнд:

**Бодлого, интституцийн түвшинд:**

- Кодекс Алиментариусын холбогдох стандартуудыг хэрэгжүүлэхийн тулд ДМАЭМБ-ын зохих стандартуудыг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлын үндэсний эрх бүхий байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Дөрвөн талт хамтын ажиллагааны зөвлөмжийг харгалзахын сацуу ДМАЭМБ болон Кодекс Алиментариус Хорооноос боловсруулсан хүнсний аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг уялдуулах;
- Шинэлэг шийдлүүдийг боловсруулах, хүнсний хяналтын тогтолцоог сайжруулах, хүнсний аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх, хүнсний аюулгүй байдлын хэлэлцээр, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх;
- Эрсдэлийн удирдлагыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хүнсний стандартыг боловсруулах, шинэчлэх, хүнсний лабораторийн шинжилгээг сайжруулах, хяналт шалгалтыг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээнд ажиллагсдыг сургахад хөрөнгө оруулах, нөөцөөр хангах.

**Хөтөлбөрийн түвшинд:**

- ДМАЭМБ болон Кодекс Алиментариусын стандартууд болон импортлогч орнуудын шаардлагад үндэслэн уулзалт зохион байгуулах, хүнсний аюулгүй байдлын үндэсний хууль тогтоомжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Мал эмнэлэг, нийтийн эрүүл мэнд, хөдөө аж ахуй, байгаль орчны чиглэлийн эрх бүхий удирдах байгууллагууд болон холбогдох бусад талууд хоорондын хүнсний аюулгүй байдлын талаарх зохицуулалтыг үндэсний болон бүсийн түвшинд сайжруулах;
- Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хариуцдаг эрх бүхий удирдах байгууллагуудын "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалд нийцсэн үндэсний, бүсийн, орон нутгийн салбар дундын хамтын ажиллагааг дэмжих;
- Бичил биетний эсрэг эм зэрэг малын эмийн бүтээгдэхүүний хариуцлагатай хэрэглээг хангах чиглэлээр Мал эмнэлгийн албанд дэмжлэг үзүүлэх;
- "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлал, "Малчны хотноос хэрэглэгчийн ширээ хүртэл" стратегитай холбоотойгоор хүнсний аюулгүй байдлын шинжлэх ухааны мэдлэг, нотолгоо, технологийг бий болгох, харилцан солилцохыг дэмжих.



World Organisation  
for Animal Health

*Нэг эрүүл мэндийн бодлогын*

*товч танилцуулга*

**Техникийн түвшинд:**

- Аюултай хүнснээс шалтгаалсан эрсдэлийг бууруулах зорилгоор үндэсний хүнсний аюулгүй байдлын эрх бүхий удирдах байгууллагуудтай хамтран фермийн түвшинд болон хүнсний сүлжээний янз бүрийн үе шатанд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах;
- Хүнсний сүлжээний оролцогч бүрт зориулсан мэдээлэл харилцааны стратеги, тодорхой мессежээр дамжуулан зан үйлийг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх.

## 5. “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын дор бичил биетний тэсвэржилттэй тэмцэх нь

*Малын эрүүл мэндийн салбарын хэтийн төлөв*

### Хураангуй

Бичил биетний тэсвэржилт (ББТ) нь халдварыг эмчлэх чадварыг бууруулдаг тул дэлхийн хүн ам, амьтан, ургамлын эрүүл мэндэд аюул занал учруулдаг. Энэ нь хөдөө аж ахуйн хүнсний тогтолцоо, хүн эмнэлэг, мал эмнэлэг зэрэг янз бүрийн салбарт бичил биетний эсрэг эмийг буруу хэрэглэсэнтэй холбоотой юм. ББТ нь амьтны популяци, хүн амын дунд, ургамал, хүрээлэн буй орчинд тархаж амьтан, хүн, ургамлын өвчний эмчилгээний үр нөлөөг өөрчлөх чадвартай. 2019 онд 1.27 сая хүн эмэнд тэсвэртэй бактерийн халдварын улмаас нас барсан гэсэн тооцоо бий. ББТ нь хүн, амьтны эрүүл мэндэд учирч буй дэлхийн хамгийн том 10 эрсдэлийн нэг бөгөөд дэлхий нийтийн амжиргаа, хүнсний баталгаат байдалд аюул занал учруулж байна. ББТ-ийг хянахгүй хэвээр орхивол өөр олон халдвар эмчлэгдэх боломжгүй, амь насанд аюултай болно. ББТ нь бүх улс оронд тохиолддог хэдий ч бага, дунд орлоготой орнууд, ялангуяа Африк, Ази, Латин Америкт түүний дарамт харьцангуй өндөр байна.

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) нь малын эрүүл мэндийн салбарт ББТ-ийн эсрэг тэмцлийг удирдахад гол байр суурь эзэлдэг. Тус байгууллага нь халдварт болон зооноз өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эмчлэхэд ашиглаж буй бичил биетний эсрэг эм болон бусад хувилбарын (жишээ нь, вакцин) сайн түршлага, биохамгааллын арга хэмжээ, мал аж ахуйн сайн дадлыг сурталчлах чиглэлээр үндэсний Мал эмнэлгийн албадтай хамтарч ажилладаг. ББТ-ийг тархахаас сэргийлэх зорилгоор ДМАЭМБ-аас Бичил биетний тэсвэржилт ба бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээний стратеги боловсруулсан. Энэхүү стратегийн гол зорилтуудын нэг нь мал амьтны бичил биетний эсрэг эмийн хэрэглээний дэлхийн цахим өгөгдлийн сан (ANIMUSE)-гаар дамжуулан тандалт хийх замаар мэдлэгийг арвижуулах явдал юм. ББТ нь амьтан-хүн-хүрээлэн буй орчны газар нутгийн давхцал дах бүх салбарт нөлөөлдөг тул дэлхий нийтийн эрүүл мэндийн өмнө тулгарч буй энэхүү аюул заналыг хамтдаа даван туулах зорилгоор ДМАЭМБ нь Нэг эрүүл мэнд үзэл баримтлалыг ББТ-ийг цогцоор нь шийдвэрлэхэд ашиглаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), ДМАЭМБ-аас бүрдсэн Нэг эрүүл мэндийн Дөрвөн талт хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндэд учирдаг аюултай илүү үр дүнтэй тэмцэх зорилгоор тогтолцоо, чадавхаа нэгтгэх Нэг эрүүл мэндийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө (2022–2026 он) (ОН JPA) боловсруулсан. ДМАЭМБ нь мал эмнэлгийн салбарт ББТ-д анхаарал хандуулсан Үйл ажиллагааны чиглэл 5-ын бодлогыг уялдуулахад дэмжлэг үзүүлж байна.

Бодлогын зөвлөмж

ДМАЭМБ нь дэлхийн Дөрвөн талт уриалгын дагуу "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалыг бэхжүүлэх, малын эрүүл мэндийн салбар болон бусад салбарт ББТ-тэй тэмцэх зорилгоор дараах бодлогод суурилсан шийдлүүдийг зөвлөмж болгож байна. Үүнд:

**Бодлого, институцийн түвшинд:**

- Тэжээвэр болон зэрлэг амьтан, хүн, ургамалд ялгаагүй нөлөөлдөг түл ББТ-тэй тэмцэхэд олон салбар, олон мэргэжлийг хамруулсан "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалыг хэрэгжүүлэх;
- Тайлан мэдээний чанарыг сайжруулах, бичил биетний эсрэг эмийн хэрэглээ болон малын эрүүл мэндийн өгөгдлийг ANIMUSE болон Дэлхийн малын эрүүл мэндийн мэдээллийн систем (WAHIS)-д мэдээлэх явдлыг дэмжих зорилгоор үндэсний болон фермийн түвшинд ББТ-ийн өгөгдөл цуглуулахад нь зориулж хангалттай нөөц хуваарилах;
- ББТ-тэй холбоотойгоор бага, дунд орлоготой орнуудын Мал эмнэлгийн албанд санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэх;
- Олон улсын стандартад нийцсэн бичил биетний мэдрэг чанарын шинжилгээний аргуудыг ашиглах зэргээр Маскатын тунхагт дурдсанчлан 2030 он гэхэд хөдөө аж ахуй, мал аж ахуй салбарт бичил биетний эсрэг эмийн нийт хэрэглээг 30-аас доошгүй хувиар бууруулах;
- Нэг эрүүл мэндийн бүх түвшний олон талт оролцогч талуудын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар ББТ-ийн эсрэг дэлхийн хөдөлгөөнийг идэвхжүүлэхийн тулд ББТ-ийн Олон талт түншлэлийн платформын үйл ажиллагаа, оролцоонд дэмжлэг үзүүлэх.

**Хөтөлбөрийн түвшинд:**

- Бичил биетний эсрэг эмийн хэрэгцээг хязгаарлах, өөр хувилбарыг хэрэглэхийг дэмжих зорилгоор мал амьтны вакцинжуулалтын арга хэмжээг сайжруулах, дэмжих;
- ДМАЭМБ-ын олон улсын стандартад нийцүүлэн үндэсний болон бүсийн түвшинд бичил биетний эсрэг эмийн хариуцлагатай, зохистой хэрэглээний заавар боловсруулах, шинэчлэх;
- Мал амьтанд зориулсан бичил биетний эсрэг эм үйлдвэрлэх, түгээх, худалдах, ашиглах, устгах чиглэлээр сайн дадал нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хувийн хэвшил, тэр дундаа эм үйлдвэрлэлийн салбартай төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хамтарч ажиллах;
- Нийтийн эрүүл мэнд, малын эрүүл мэндийн салбарууд эмийн чанарын хяналтын лабораторио дундаа ашиглах зэргээр нөөц бололцоогоо хамтарч ашиглах явдлыг дэмжих;
- Мал амьтанд бичил биетний эсрэг эмийг хариуцлагатай хэрэглэж, эрүүл малд мал эмнэлгийн бус зорилгоор ашиглахаас зайлсхийх тухай сурталчлах (жишээ нь, өсөлт дэмжих, ашиг шим

***товч танилцуулга***

нэмэгдүүлэх зорилгоор), мөн үржлийн хөтөлбөр, малын тэжээллэгийг сайжруулах зэрэг ашиг шим нэмэгдүүлэх бусад аргуудыг судлах;

- Мал эмнэлгийн эмийн шинэ бүтээгдэхүүн, түүн дотор аутолог вакцин, бичил биетний эсрэг эмээс бусад хувилбар, ББТ-ийг хурдан, хямд оношлох шинжилгээний аргуудыг судлах, боловсруулах ажлыг дэмжих.

**Техникийн түвшинд:**

- ББТ-ийн лабораторийн одоогийн мөрдөж буй болон шинэ арга зүй (жишээ нь, бүтэн геномын дараалал тогтоох), биохамгааллын дадлын талаар сургалт зохион байгуулах, боловсрол олгох замаар үндэсний Мал эмнэлгийн албаны чадавхыг бэхжүүлэх;
- ББТ-ийн эсрэг нэгдсэн арга хэмжээг мэдээллээр хангах зорилгоор мал эмнэлэг, хүн эмнэлэг, байгаль орчны салбарууд хоорондын мэдээлэл харилцаа, өгөгдөл солилцоог дэмжих;
- Малыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч, мал амьтан эзэмшигч, олон нийт болон холбогдох бусад талуудын үр дүнтэй мэдээлэл харилцаа, боловсрол, сургалтаар дамжуулан ББТ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг зузаатгах.

## 6. Байгаль орчны асуудлыг малын эрүүл мэндийн салбарт тусгах нь

### Хураангуй

Байгаль орчны доройтол нь малын эрүүл мэндэд ихээхэн эрсдэл учруулдаг ч үндэсний мал эмнэлгийн бодлого, сургалтад төдийлөн хөндөгддөггүй. Зэрлэг амьтдын амьдрах орчныг сэргээх хөдөө аж ахуйн шийдлүүдийг нэвтрүүлэхэд фермерүүдэд түлхэц болохуйц байгаль орчны бодлого хэрэгжүүлэх зэрэг ойлголт нэмэгдүүлсэн, сургамжтай ажлууд хийгдэж байна. Гэсэн хэдий ч газар ашиглалтын өөрчлөлт, амьдрах орчны хүмигдалт, бичил биетний эсрэг эм бэлдмэлийг буруугаар ашиглах, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг нь өвчний тархалтыг нэмэгдүүлж, мал амьтны эрүүл мэндэд заналхийлж байна. Экосистемийг сүйтгэж, биологийн олон янз байдалд нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлт нь халууны дарамт, ус, тэжээлийн эх үүсвэрийн хомсдол үүсгэх зэргээр малын эрүүл мэндэд шууд болон шууд бусаар, янз бүрийн замаар нөлөөлж байна. Ийм учраас Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) нь илүү тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог бий болгохын тулд экосистемийг хамгаалах, өөрчлөх, мөн байгаль орчны хэтийн төлвийг олон салбарын хамтын ажиллагаатай уялдуулах замаар мал эмнэлгийн салбарын мэргэжилтнүүдийн Нэг эрүүл мэндийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Зохистой экосистемтэй эрүүл байгаль орчин нь мал амьтны эрүүл мэндэд маш чухал. Байгаль орчин, малын эрүүл мэндийн салбарууд олон салбарын түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд Нэг эрүүл мэндийн асуудлаар хүчээ нэгтгэх ёстой. Мал аж ахуйн үйлдвэрлэлд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох стратеги хэрэгжүүлэх нь малын эрүүл мэндийг хамгаалах, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад нэн ач холбогдолтой. Малын эрүүл мэндийн асуудлыг байгаль орчин, гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогод тусгах, түүнчлэн урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад олгох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь байгаль орчны доройтлын малын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, уур амьсгалд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй малын эрүүл мэндийн тогтолцоо, үйлчилгээг бий болгоход зайлшгүй шаардлагатай алхам юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), ДМАЭМБ-аас бүрдсэн Нэг эрүүл мэндийн Дөрвөн талт хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндэд учирдаг аюултай илүү үр дүнтэй тэмцэх зорилгоор тогтолцоо, чадавхаа нэгтгэх Нэг эрүүл мэндийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө (2022–2026 он) (ОН JPA) боловсруулсан бөгөөд Үйл ажиллагааны чиглэл 6 нь байгаль орчны салбарыг Нэг эрүүл мэндийн үйл ажиллагаанд хамруулах тухай юм.

ДМАЭМБ нь мал эмнэлгийн салбарт дээрх Үйл ажиллагааны чиглэл 6-гийн бодлогыг уялдуулахад дэмжлэг үзүүлж, байгаль орчны асуудлыг малын эрүүл мэндийн салбарт хэрхэн тусгах талаар чиглүүлэг өгдөг.

Бодлогын зөвлөмж

ДМАЭМБ нь “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалын дор байгаль орчин, мал эмнэлгийн салбаруудын уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор дараах бодлогод суурилсан шийдлүүдийг зөвлөмж болгож байна. Үүнд:

**Бодлого, институцийн түвшинд:**

- Хүн, малын эрүүл мэндээс гадна байгаль орчны салбарыг хамруулах зорилгоор салбар дундын хамтын ажиллагаа, олон түвшний засаглалыг бэхжүүлэх;
- Агроэкологи, тогтвортой загас агнуур, мал аж ахуй зэрэг үйлдвэрлэлийн тогтолцоог өөрчлөхөд томоохон байгууллагуудыг татан оролцуулах;
- Биологийн олон янз байдлын алдагдлыг зогсоох, байгалийг нөхөн сэргээх зэрэг Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (Nationally Determined Contributions) болон үүр амьсгалын бусад үүрэг амлалтад малын эрүүл мэндийн асуудлыг тусгах;
- Малын эрүүл мэндийг байгаль орчин, биологийн олон янз байдал, үүр амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, бодлоготой уялдуулах;
- Эпидеми, цартахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахын тулд үүр амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, биологийн олон янз байдлыг сэргээхэд чиглэсэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх;
- Хүн-амьтан-хүрээлэн буй орчны газар нутгийн давхцалд эрүүл мэндэд учирдаг аюулыг бууруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хувь хүний зан үйлийг өөрчлөх хөшүүргийг боловсронгуй болгох;
- Бодлого, стратеги төлөвлөгөөнд уугуул иргэд, орон нутгийн бүлгүүдийн мэдлэг, бодол санааг тусгах.

**Хөтөлбөрийн түвшинд:**







- Байгаль орчин, мал эмнэлгийн салбаруудыг нийтийн эрүүл мэндийн салбартай эн тэнцүү багтаасан Нэг эрүүл мэндийн салбар дундын зохицуулалтын механизм бий болгох;
- Нэг эрүүл мэндийн үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлэхийн тулд Нэг эрүүл мэндийн салбар дундын зохицуулалтын механизмаар дамжуулан төсвийг бүх салбаруудад тэгш хуваарилах;
- Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой малын эрүүл мэндийн дэд бүтэц, технологийг дэмжих;
- Нийгмийн бүлгүүдийн “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалтай холбоотой мэдлэг, оролцоог дээшлүүлэх.



**Техникийн түвшинд:**

- Хүрээлэн буй орчны хувьсагчдыг харгалзсан (жишээ нь, цаг агаарын хэв маяг, температур, агаарын чанар, хөрсний бүтэц) мал амьтны өвчний тандалтын (зэрлэг амьтдыг оруулан) хэрэгсэл, арга техникийг боловсруулах;
- Уур амьсгал, гамшигт тэсвэртэй эрүүл мэндийн тогтолцоог бий болгож, тогтвортой хадгалах зорилгоор мал эмнэлгийн мэргэжилтнүүд болон тэдэнд боловсрол олгох байгууллагуудыг чадавхжуулах;
- Байгаль орчин, биологийн олон янз байдлын хил хязгаарын хүрээнд агроэкологи, тогтвортой загас агнуур, мал аж ахуй зэргийг багтаасан мал амьтны гаралтай хүнсний тогтолцоог бэхжүүлэх боломжуудыг хөгжүүлэх, дэмжих;
- Байгаль орчин, малын эрүүл мэндийн салбар хоорондын судалгаа, хөгжлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх;
- Нэг эрүүл мэндийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ уугуул иргэд, орон нутгийн бүлгүүдтэй хамтарч ажиллах.

Баримт бичгүүдийг бүрэн эхээр нь эндээс авна уу:

1	Нэг эрүүл мэнд		<a href="https://www.woah.org/app/uploads/2024/04/en-one-health-policy-brief-.pdf">https://www.woah.org/app/uploads/2024/04/en-one-health-policy-brief-.pdf</a>
2	Шинэ болон сэргэж буй зоонозын эпидеми, цартахалтай тэмцэхэд "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалын ач холбогдол		<a href="https://www.woah.org/app/uploads/2024/06/oh-tackling-zoonotics-pandemics.pdf">https://www.woah.org/app/uploads/2024/06/oh-tackling-zoonotics-pandemics.pdf</a>
3	Нутагшмал зооноз, халуун орны болон дамжуулагчдаар дамждаг орхигдсон өвчнүүдтэй мал эмнэлгийн салбар "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалын дор тэмцэх нь		<a href="https://www.woah.org/app/uploads/2024/06/en-controlling-endemic-zoonotic-vbds-in-the-animal-health-sector.pdf">https://www.woah.org/app/uploads/2024/06/en-controlling-endemic-zoonotic-vbds-in-the-animal-health-sector.pdf</a>
4	Хүнсний аюулгүй байдлын эрсдэлд малын эрүүл мэндийн салбар анхаарал хандуулах нь		<a href="https://www.woah.org/app/uploads/2024/06/addressing-food-safety-risks-in-the-ah-sector-with-a-oh-approach.pdf">https://www.woah.org/app/uploads/2024/06/addressing-food-safety-risks-in-the-ah-sector-with-a-oh-approach.pdf</a>
5	"Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалын дор бичил биетний тэсвэржилттэй тэмцэх нь		<a href="https://www.woah.org/app/uploads/2024/06/tackling-amr-using-the-one-health-approach.pdf">https://www.woah.org/app/uploads/2024/06/tackling-amr-using-the-one-health-approach.pdf</a>
6	Байгаль орчны асуудлыг малын эрүүл мэндийн салбарт тусгах нь		<a href="https://www.woah.org/app/uploads/2024/06/en-incorporating-environmental-considerations-into-the-ah-sector.pdf">https://www.woah.org/app/uploads/2024/06/en-incorporating-environmental-considerations-into-the-ah-sector.pdf</a>